



**ЦАХИР СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

**Аудитын код: АРА-
2017/16/СТА-ТТЗ**

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70333141
Цахим хаяг:

Аудитын менежер:
Утас: 70332860
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Архангай
аймгийн Аудитын газар
Байршил: Эрдэнэбулган сум
Цахим хуудас:
www.audit.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт 3: Менежмент захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэл

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	Орлого	12
3.2	Өр төлбөр	13
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	22
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	24

1 Аудитын гэрчилгээ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

ЦАХИР СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ Д. ГАЛБААТАР ТАНД ТАНИЛЦУУЛЖ БАЙНА.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төвшрүүлэх сумын ТЭЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цахир сумын ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.03.10 - наас 2017.03.25 – ны хооронд хийж, аудитын тайланг эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Ахлах аудитор Н.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Цахир сумын ТЭЗ 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа төрийн аудитын байгууллагад 2017.03.07-ны өдөр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Цахир сумын ТЭЗ Монгол улсын ЗЗНДТУТХуулийн 18.1 дэх хэсэгт “Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд өөрийн эрхлэх хүрээний асуудлыг онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ” гэсэн эрхэм зорилгын дор Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.Үүнд:

Цахир сумын ТЭЗ дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Цахир сумын ТЭЗ “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэд хүнд сурталгүй аливаа чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдсан цэгцтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгоно.” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Цахир сумын ТЭЗ Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэд хүнд сурталгүй аливаа чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдсан цэгцтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгоно.” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Цахир сумын Засаг дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан Төсвийн орлогын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, төсвийн эх үүсвэрийн ангилал, Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангилал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”, “Журам шинэчлэн батлах тухай” 2015 оны “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-ыг 2 дугаар хавсралтыг 341 дүгээр тушаалаар батлан тус бүр мөрдөн ашиглаж байна.

Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цахир сумын ТЭЗ төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Цахир сумын ТЕЗ санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “plastic” программ хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Цахир сумын ТЕЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 17 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.5 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 2 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 6 буюу “бага” байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардлын дүнгээс материаллаг түвшинг сонгон авсан шалтгаан нь тухайн байгууллагын тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзлээ.

Цахир сумын ТЕЗ –ийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1928.4 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 19.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 2 чиглэлээр 2 эрсдэлтэй асуудалд 2 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 100 хувь буюу 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	3	23.4	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	3	23.4	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитаар сумын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн талаар дараахь зөрчил илэрлээ.

- Цахир сумын ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 14/04 тоот тогтоолоор төсвийн орлогын төлөвлөгөөг 32.1 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 41.3 сая төгрөгөөр төвлөрч 128.6%-иар биелсэн ба нийт дүнгээрээ 9.2 сая

төгрөгөөр давсан хэдий ч 8 нэр төрлийн орлого 0.1- 5.4 сая төгрөгөөр давж , 4 нэр төрлийн орлого 0.3-1.0 сая төгрөгийн хооронд буюу нийт **2.3** сая төгрөгөөр тасарсан нь орлогын төлөвлөлт оновчгүй, шахуу төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангуулж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх

- Мөн Сум хөгжүүлэх сангийн орлогыг **72.2** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр **53.7** сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө **74.4** хувьтай байгаа бөгөөд орлогын төлөвлөгөөг **18.5** сая төгрөгөөр тасарсан байна.

Шийдвэрлэсэн нь: Сум хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтөнд онцгой анхаарч холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмж хүргүүлэх

- Цахир сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт **2.6** сая төгрөгийн өр төлбөртэй байгаагийн 1.7 сая төгрөг нь Сумын ЗДТГ-ийн, 0.4 сая төгрөг нь бүрэн дунд сургуулийн өр байна. Төсвийн байгууллагууд өр төлбөртэй байгаа нь “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Цахир сумын Засаг дарга өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1628.9 сая , хөрөнгийн зардалд 73.5 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1520.7	1447.3	95.2%	73.4
1.1	Урсгал зардал	1341.2	1337.9	99.7%	3.3
1.2	Хөрөнгийн зардал /ОНХС/	109.5	109.4	99.9%	0.1

1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл/ СХС/	70.0	0	0	70.0
-----	---	------	---	---	------

Тайлант оны төсвийн гүйцэтгэл **95.2** хувьтай өөрөөр хэлбэл **73.4** сая төгрөг зарцуулагдаагүй үлдэгдэл гэж үзэхээр байна. Үүнд: төсөвт байгууллагуудын урсгал зардлаас хэмнэгдсэн үлдэгдэл буюу төвлөрүүлсэн **2.6** сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл **0.1** сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн санхүүжигдээгүй үлдэгдэл буюу тухайн онд төлөвлөсөн хэмжээгээр эргэн төлөгдөх нөхцөлөөр зээлд олгоогүй **70.0** сая төгрөг, урсгал зардлын хэмнэлт буюу өөрийн орлогын төвлөрүүлэлттэй холбоотой дутуу санхүүжигдсэн **0.7** сая төгрөг тус тус байна

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт **24.9** сая төгрөг зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Цахир сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Цахир сумын ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрын 12 тоот тогтоолоор төсвийн орлогын төлөвлөгөөг 29.9 сая төгрөгөөр баталж 34.8 сая төгрөг төвлөрч 116.4%-иар биелэсэн хэдий ч 1 нэр төрлөөр буюу үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 0.6 сая төгрөгөөр тус тус тасарсан бөгөөд аудитаас дараах зөвлөмжийг хүргүүлсэн. Үүнд:

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр жигд хангуулж ажиллах
- Орлого тасарч байгаа шалтгааныг орлогын нэр төрөл бүр дээр судлан, төлөвлөлтийг оновчтой болгох зөвлөмж хүргүүлсэн.

Гэсэн ч өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй энэ онд мөн л орлого нэр төрлөөрөө тасарсан байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цахир сумын ТЭЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цахир сумын ТЭЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж **“Зөрчилгүй”** санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.9-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг бус, материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Цахир сумын ТЭЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг дансдаар ангилан үзүүлэв.

3.1 Орлого

Илрүүлэлт

Цахир сумын ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 14/04 тоот тогтоолоор төсвийн орлогын төлөвлөгөөг 32.1 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 41.3 сая төгрөгөөр төвлөрч 128.6%-иар биелсэн ба нийт дүнгээрээ 9.2 сая төгрөгөөр давсан хэдий ч 3 нэр төрлийн орлого 0.3-1.0 сая төгрөгөөр давж, 5 нэр төрлийн орлого 0.1- 5.4 сая төгрөгийн хооронд буюу нийт **2.3** сая төгрөгөөр тасарсан нь орлогын төлөвлөлт оновчгүй, шахуу төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

Зөвлөмж

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр жигд хангуулж ажиллах
- Орлого тасарч, давж байгаа шалтгааныг орлогын нэр төрөл бүр дээр судлан, төлөвлөлтийг оновчтой болгох
- Төсвийн тухай хуулийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах
- Сум хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтөнд **онцгой анхаарч** холбогдох арга хэмжээг авч ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Эрсдэл

- Сумын ИТХ-аар баталсан Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө орлогын нэр төрлөөр биелэгдээгүйгээс санхүүжилтийн эх үүсвэр дутагдах эрсдэлтэй байх
- Орон нутгийн Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүрэг биелэгдэхгүй байх

Зөвлөмжийн биелэлтийг 2017.06.15-ны дотор албан тоотоор манайд ирүүлнэ үү.

3.2 ӨР ТӨЛБӨР

Илрүүлэлт

- Цахир сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт **2.6** сая төгрөгийн өр төлбөртэй байгаагийн 1.7 сая төгрөг нь Сумын ЗДТГ-ийн, 0.4 сая төгрөг нь бүрэн дунд сургуулийн өр байна. Төсвийн байгууллагууд өр төлбөртэй байгаа нь “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж

- Өр төлбөрийг барагдуулахад тодорхой арга хэмжээ авч холбогдох байгууллагад санал хүргүүлэн шийдвэрлүүлэх.
- Цаашид Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс өр төлбөр үүсгэхгүй байхад ТЕЗ-ийн хувьд анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Төсвийн захирагчийн хариу

Эрсдэл

- Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх
- Төсвийн хөрөнгийн үр ашиг буурах

Зөвлөмжийн биелэлтийг 2017.06.15-ны дотор албан тоотоор манайд ирүүлнэ үү

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	538,407,489.33	599,377,975.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	68,785,823.38	110,183,549.18
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	68,785,823.38	110,183,549.18
31210	Төгрөг	68,785,823.38	110,183,549.18
31211	Төрийн сангийн харилцах	14,377,862.00	9,373,639.80
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	54,407,961.38	100,809,909.38
33	АВЛАГА	228,093,919.00	173,215,524.00
33500	Бусад авлага	228,093,919.00	173,215,524.00
33510	Байгууллагаас авах авлага	1,238,000.00	230,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	226,855,919.00	172,985,524.00
35	БАРАА МАТЕРИАЛ	238,809,746.95	315,978,902.78
35100	Түүхий эд материал	55,261,197.75	61,141,109.78
35110	Тусгай зориулалттай материал	49,821,612.00	54,308,512.00
35130	Эм боох материал	5,439,585.75	6,832,597.78
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	0.00	69,501,098.00
35400	Хангамжийн материал	80,424,549.20	72,107,695.00
35410	Бичиг хэргийн материал	10,820,984.00	7,391,191.00
35420	Аж ахуйн материал	58,378,614.50	57,367,248.50
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	330,000.00
35440	Түлш, шатах тослох материал	10,092,012.00	4,189,125.00
35460	Хүнсний материал	1,132,938.70	2,830,130.50
35600	Мал амьтад	103,124,000.00	113,229,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	2,718,000.00	0.00
36300	Тэжээлийн нөөц	2,718,000.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,591,507,158.86	2,799,528,063.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,591,507,158.86	2,799,528,063.69
39200	Биет хөрөнгө	2,590,558,675.64	2,798,796,213.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,438,940,135.00	2,459,652,935.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-364,865,908.71	-419,094,596.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	61,245,000.00	93,745,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,716,948.22	-26,322,573.14

39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	326,192,520.75	356,216,430.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-150,364,195.78	-196,224,118.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	177,663,223.87	190,594,918.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	-76,256,950.50	-88,889,770.62
39209	Зам, гүүрийн байгууламж	222,300,000.00	222,300,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-177,840,000.00	-188,955,000.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0.00	204,190,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	132,703,440.00	180,455,440.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-20,136,708.45	-27,829,725.21
39216	Дуусаагүй барилга, байгууламж	14,141,314.00	14,141,314.00
39217	Ном	23,553,753.68	24,815,959.68
39300	Биет бус хөрөнгө	948,483.22	731,850.11
39301	Програм хангамж	1,608,000.00	1,608,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-659,516.78	-876,149.89
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,129,914,648.19	3,398,906,039.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	34,277,061.00	2,095,883.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	34,277,061.00	2,095,883.00
41300	Өглөг	34,277,061.00	2,095,883.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	22,042,128.00	403,483.00
41360	Бусад өглөг	12,234,933.00	1,692,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	12,234,933.00	1,692,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,095,637,587.19	3,396,810,156.65
51	Засгийн газрын хувь оролцоо	3,095,637,587.19	3,396,810,156.65
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,529,417,324.69	1,529,417,324.69
51200	Хуримтлагдсан үр дүн	1,043,069,029.56	1,344,241,599.02
51210	Өмнөх үеийн үр дүн	812,113,667.45	1,052,166,821.56
51220	Тайлант үеийн үр дүн	230,955,362.11	292,074,777.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	523,151,232.94	523,151,232.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,129,914,648.19	3,398,906,039.65

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,005,798,168.68	2,219,978,131.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	31,651,740.00	32,251,339.80
110	Орлогын албан татвар	14,542,380.00	15,492,109.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	14,139,380.00	15,492,109.80
110002	Үйл ажиллагааны орлого	14,139,380.00	15,492,109.80
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	403,000.00	0.00
110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	403,000.00	0.00
113	Хөрөнгийн албан татвар	758,000.00	4,857,000.00
113002	Бууны албан татвар	758,000.00	4,857,000.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	16,351,360.00	11,902,230.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,372,720.00	5,294,190.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,300,690.00	1,303,470.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,000,030.00	2,320,000.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,072,000.00	1,670,720.00
1181	Газрын төлбөр	4,175,300.00	774,820.00
118102	Дуудлага худалдаа	4,175,300.00	774,820.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	6,803,340.00	5,833,220.00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	6,605,340.00	5,833,220.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	198,000.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	107,340,654.38	491,743,331.00
120	Нийтлэг татварын бус орлого	107,340,654.38	491,743,331.00
120003	Торгуулийн орлого	1,201,200.00	1,885,380.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	104,139,454.38	483,079,336.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,340,964.38	6,857,822.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	0.00	14,377,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	70,798,490.00	461,843,714.00
120009	Бусад орлого	2,000,000.00	6,778,615.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,866,805,774.30	1,695,983,461.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,079,920,288.30	1,046,337,400.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	54,500,552.00	0.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,025,419,736.30	1,046,337,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,430,162.00	24,908,818.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	688,990.00	0.00
